



**ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**



**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

***Халамжийн сангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит***

**Аудитын код: ДОА-2021/1/СТА-ЗГТС**

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Чойбалсан хот

2021 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга

бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Ахлах аудитор: М.Ухаанбилэг

Утас: 7058-4207, Цахим хаяг: ukhaanbilegm@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ДОА	Дорнод аймаг
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ХХҮЕГ	Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний ерөнхий газар
ХХҮГ	Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газар




## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	3
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	3
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	3
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	3
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	3
3. Аудитын тайлан.....	4
3.1. Ерөнхий зүйл.....	4
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	4
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт.....	4
3.4. Материаллаг байдал.....	5
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	5
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	7
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	8
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	8
3.9. Аудитын илрүүлэлт.....	9
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	9
Аудитын зөвлөмж.....	10
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	10
4. Менежментийн захидал.....	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	12



1.Хараат бус аудиторын дүгнэлт



Халамжийн сангийн 2020 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1.Хараат бус аудиторын дүгнэлт




ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг  
ЗДП-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021.02.24 № 210

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г САНАЛ ДҮГНЭЛТ Г



ДОРНОД АЙМГИЙН ХӨДӨЛМӨР,  
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН  
ДАРГА Н.МОНХГЭРЭЛ ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Халамжийн сангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Халамжийн сангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Нийгмийн халамжийн хэлтэс 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтээр 93.1 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

ДОА-2021/1/СТА-ЗГТС



ХТТ  
ТӨС  
МОНГОЛ  
АУДИТ  
ДИВАИЗ

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,572,219.06	118,519.54
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3,572,219.06	118,519.54
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	3,572,219.06	118,519.54
3121	Төгрөг	3,572,219.06	118,519.54
31213	Арилжааны банк дахь харилцах Улсын төсөв	3,479,405.68	117,262.34
31214	Арилжааны банк дахь харилцах Орон нутаг	92,813.38	1,257.20
33	АВЛАГА	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	-	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	-	-
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	-	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,572,219.06	118,519.54
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	8,456,130.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	8,456,130.00
413	Өглөг	-	8,456,130.00
4136	Бусад өглөг	-	8,456,130.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	8,456,130.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,572,219.06	(8,337,610.46)
51	Засгийн газрын хувь оролцоо	3,572,219.06	(8,337,610.46)
512	Хуримтлагдсан үр дүн	3,572,219.06	(8,337,610.46)
51210	Өмнөх үеийн үр дүн	(135,257,418.79)	3,572,219.06
51220	Тайланг үеийн үр дүн	138,829,637.85	(11,909,829.52)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,572,219.06	118,519.54

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайланг оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	13,578,229,349.12	14,091,058,110.52
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	32,983,815.12	9,601,000.52
120	Нийтлэг татварын бус орлого	32,983,815.12	9,601,000.52
120002	Хүүгийн орлого улсын төсөв	16,027,517.70	4,813,198.49
120003	Хүүгийн орлого орон нутаг	199,963.42	70,593.85
120008	Бусад орлого Улсын төсөв	13,449,460.00	3,814,308.18
120009	Бусад орлого орон нутаг	3,306,874.00	902,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	13,545,245,534.00	14,081,457,110.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	13,362,065,534.00	13,898,277,110.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	13,898,277,110.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	13,362,065,534.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	183,180,000.00	183,180,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	183,180,000.00	183,180,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	13,574,657,130.06	14,102,967,940.04
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13,574,657,130.06	14,102,967,940.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,456,400.00	4,652,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,456,400.00	4,652,700.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	5,456,400.00	4,652,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,569,200,730.06	14,098,315,240.04
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,236,676,268.00	13,853,187,170.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	13,236,676,268.00	13,853,187,170.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	264,829,998.02	210,806,020.01
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	264,829,998.02	210,806,020.01
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөгч захирагчдад олгох татаас	67,694,464.04	34,322,050.03
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	67,694,464.04	34,322,050.03
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	3,572,219.06	(11,909,829.52)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	3,572,219.06	(11,909,829.52)



### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>13,578,229,349.12</b>	<b>14,096,565,910.52</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>32,983,815.12</b>	<b>15,108,800.52</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	32,983,815.12	15,108,800.52
120002	Хүүгийн орлого улсын төсөв	16,027,517.70	4,813,198.49
120003	Хүүгийн орлого орон нутаг	199,963.42	70,593.85
120008	Бусад орлого улсын төсөв	13,449,460.00	3,814,308.18
120009	Бусад орлого орон нутаг	3,306,874.00	902,900.00
120014	Буцаасан орлого улсын төсөв		5,423,300.00
120015	Буцаасан орлого орон нутаг		84,500.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>13,545,245,534.00</b>	<b>14,081,457,110.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	13,362,065,534.00	13,898,277,110.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		13,898,277,110.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	13,362,065,534.00	
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	183,180,000.00	183,180,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	183,180,000.00	183,180,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>13,574,717,381.27</b>	<b>14,100,019,610.04</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>13,574,717,381.27</b>	<b>14,100,019,610.04</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>133,429,960.00</b>	<b>4,652,700.00</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	133,429,960.00	4,652,700.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	5,446,400.00	4,652,700.00
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	127,983,560.00	
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>13,441,287,421.27</b>	<b>14,095,366,910.04</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	13,244,010,378.00	13,850,238,840.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	13,244,010,378.00	13,850,238,840.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	191,541,873.27	210,806,020.01
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	191,541,873.27	210,806,020.01
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох гатаас, санхүүжилт</b>	5,735,170.00	34,322,050.03
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,735,170.00	34,322,050.03
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>3,511,967.85</b>	<b>(3,453,699.52)</b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	3,511,967.85	(3,453,699.52)
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	60,251.21	3,572,219.06
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	3,572,219.06	118,519.54

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
S01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	3,572,219.06	-	3,572,219.06
S02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
S03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-	-
S04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
S05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
S06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
S07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-	-
S08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-	-
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	3,572,219.06	-	3,572,219.06
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	3,572,219.06	-	3,572,219.06
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(11,909,829.52)	-	(11,909,829.52)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	(8,337,610.46)	-	(8,337,610.46)



## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Баглагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		3,572,219.06
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	14,081,457,110.00	13,848,407,277.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	14,081,457,110.00	13,848,407,277.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,081,457,110.00	13,848,407,277.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,081,457,110.00	13,848,407,277.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	14,081,457,110.00	13,848,407,277.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	14,081,457,110.00	13,997,265,227.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	14,081,457,110.00	13,997,265,227.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	13,898,277,110.00	13,848,407,277.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	183,180,000.00	148,857,950.00
132001	Орон нутгийн төсвөөс	183,180,000.00	148,857,950.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		3,572,219.06
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		118,519.54



### 3. Аудитын тайлан

#### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Халамжийн сангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дүгнэлтийг ХХҮГ-ын дарга Н.Мөнхгэрэл танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж өглөгийн үлдэгдэлтэй ажиллах зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 17-ноос 2021 оны 02 дугаар сарын 22-ны хооронд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор М.Ухаанбилэг хариуцаж хэрэгжүүлэв.

Халамжийн сангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 02 дугаар сарын 04-ны өдрийн 1/62 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Халамжийн сангийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

- Төрөөс олгож буй халамжийн үйлчилгээг иргэдэд хүргэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

#### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Халамжийн сангийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

ХХҮЕГ-ын хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас 2020 онд Халамжийн сангийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт хийгдээгүй байна.

Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

#### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.



Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг өмнөх жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 13,574,657,1 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 271,493.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд тайлант оны үр дүнгийн тайлангийн зардлын 14,102,967.9 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 141,029.6 мянган төгрөг болгон материаллаг байдлыг өөрчлөв.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,453.7 мянган төгрөгөөр буюу 96.7 буурсан байна. Тайлант онд мөнгөний үлдэгдэлгүй ажилласантай холбоотой байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	3,572,219.06	118,519.54	(3,453,699.52)
Авлага	-	-	-
Урьдчилгаа	0	0	-
Бараа материал	0.00	0.00	-
Үндсэн хөрөнгө	0.00	0.00	-
Хуримтлагдсан элэгдэл	0.00	0.00	-
Нийт хөрөнгө	3,572,219.06	118,519.54	(3,453,699.52)
Өр төлбөр	0.00	8,456,130.00	8,456,130.00
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,572,219.06	-8,337,610.46	(11,909,829.52)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,572,219.06	118,519.54	(3,453,699.52)

Мөнгөн хөрөнгийн данс нь арилжааны банкны хүүгийн орлогын дүнгээр үлдэгдэлтэй гарсан байна.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл нь 8,456.1 мянган төгрөг нь асаргааны тэтгэмжээ аваагүй иргэдтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл -8,456.1 мянган төгрөг болж 11,909.8 мянган төгрөгөөр буурсан өмнөх оны мөнгөн хөрөнгийн үлдэгдэл, тайлант оны өглөгийн зөрүү байна.

Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн данс нь 118,519.5 мянган төгрөг болж 3,453.6 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн зөрүү байна.

2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 512,828.7 мянган төгрөгөөр буюу 3.8 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 536,211.6 мянган төгрөгийн орлого байна. Энэ нь улсын төсвийн санхүүжилтийн орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 528.310.8 мянган төгрөгөөр буюу 3.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн зардлын данс байна.



### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 14,081,457.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 14,081,457.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 14,081,457.1 мянган төгрөгөөр баталсан байна.

#### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн үйл ажиллагааг санхүүжүүлэх 13,898,277.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 183,180.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 13,898,277.1 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 183,180.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 13,853,187.2 мянган төгрөгийг зарцуулж 210,806.0 мянган төгрөгийг улсын төсөвт, 34,322.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 13,853,187.2 мянган төгрөг буюу 98.3 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих нийт 149 мэдээллээс 101 мэдээлэл хугацаа хоцроож, орон нутгийн төсвөөс авсан санхүүжилтийг мэдээлээгүй байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 9,769.2 мянган төгрөгийн зөрчилд зөрчилд 1 төлбөрийн акт, 1 зөвлөмж өгсөн байна. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	6,197.0	1	6,197.0	-	-	-
Төлбөрийн акт	1	3,572.2	1	3,572.2			
Нийт дүн	2	9,769.2	2	9,769.2			



### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 8,456.1 мянган төгрөгийн зөрчил илрүүлж 2 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлээ.

#### **Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар шилэн дансны мэдээлэл хугацаа хоцроосон, санхүүгийн тайланг төсвийн тухай хуульд заасан цаглабараас хоцроож ирүүлсэн зөрчлүүдэд 2 албан шаардлага бичив. Үүнд:

1. Шилэн дансны нийт мэдээлбэл зохих 149 мэдээллээс 96 мэдээлэл хугацаа хоцроож, орон нутгийн төсвөөс авсан 183.1 сая төгрөгийн санхүүжилтийг мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ.” гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

2. Халамжийн сангийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2021 оны 02 дугаар сарын 04-ний өдөр ирүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т “төсвийн шууд захирагч .., жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, ..” гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

#### **Аудитын зөвлөмж**

Халамжийн тэтгэмжээ аваагүй иргэдийн 8,4 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй ажилласан талаар зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Анхааралдаа авч үзэх шаардлагатай асуудал байхгүй гэж үзлээ.

### 4. Менежментийн захидал

---

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### *Өглөгтэй холбоотой асуудал*

1.1. Илрүүлэлт: Аудитаар Халамжийн тэтгэмжээ аваагүй иргэдийн 8,4 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй ажилласан байсан.

1.2. Эрсдэл: Халамжийн тэтгэмж зорилтот хэрэглэгчдэд хугацаандаа очихгүй байх

1.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, ер төлбөр үүсгэхгүй байх.” гэснийг хэрэгжүүлж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.



Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<i>Халамжийн сангийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</i>	Аудитын код:
2021			ДОА-2021/1/СТА-ЗГТС
Шалгагдсан байгууллагын нэр:	<i>Халамжийн сан</i>		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Шилэн дансны мэдээлэл хугацаа хоцроон байршуулсан, Орон нутгийн санхүүжилт мэдээлээгүй	183,180.0	Албан шаардлага	Дарга, Нягтлан бодогч	Н.Мөнхгэрэл, Б.Алтанцэцэг
2	Санхүүгийн тайланг хугацаа хоцроон ирүүлсэн	0	Албан шаардлага	Дарга, Нягтлан бодогч	Н.Мөнхгэрэл, Б.Алтанцэцэг
3	Тайлант онд өглөгийн үлдэгдэлтэй ажилласан	8,456.1	Зөвлөмж	Дарга, Нягтлан бодогч	Н.Мөнхгэрэл, Б.Алтанцэцэг
<b>ДҮН</b>		<b>191,636.1</b>			